

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Г “Арвис итгэл ББСБ” ХХК-ийн Ү
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сэргээж,
итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.3, 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Арвис итгэл ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн зээл, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах, итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээ хийлгэж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох бүртгэлийг хийлгэсэн гэрчилгээ, ББСБ-ын дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Арвис итгэл ББСБ” /Д.Очгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН